



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 7 сарын 7 өдөр

Дугаар 225

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

2004-2005 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Энхсайхан овогтой Мажигсүрэнг Австрали улсын Канберра Их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Доржсүрэн овогтой Ариунтуяаг Англи улсын Лондон хотын Дипломатын Академийн магистрантурт олон улсын харилцааны чиглэлээр 1 жилийн хугацаагаар, ~~Доржнамжин овогтой Доржсүрэнг АНУ-ын Де Врай Их сургуулийн магистрантурт мэдээллийн системийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс тус тус суралцуулсугай.~~

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

2004-07-07 225 87

САЙД

А.ЦАНЖИД